

Их Эзэн зарлиг болгоход

Далын Зөвлөлийн

Ахлагч Брус А.Карлсон

Ажил үүргийн харагдах хэмжээнээс үл хамааран итгэл бүхий дуулгавартай байдал нь Их Эзэний удирдамж, тусламж, амар амгаланг авчрах болно.

Жил бүр загасчлахын тулд холын нэгэн нууранд очихоор жижиг онгоц хөлсөлдөг байсан байгалийг бишрэгч хоёр залуугийнн тухай нэг түүх байдаг. Амжилттай аялалынх нь дараа нисгэгч нь тэднийг авахаар эргэж иржээ. Гэвч тэрээр жижиг онгоц нь загасчдыг болон тэдний тоног төхөөрөмж, мөн барьсан загасыг дааж чадахгүйг загасчдад учирлаж, хоёр удаа нисэх хэрэгтэй гэжээ.

Мөнөөх хоёр залуу хоёр дахин нисэхэд мөнгө төлөх сонирхолгүй байлаа. Тэднийг ачаагаа сайн багласны дараа, бага зэрэг мөнгө нэмж төлөхөөр амласных нь дараа нисгэгч оролдоод үзэхээр зөвшөөрсөн ажээ.

Нисгэгч онгоцыг агаарт хүчлэн нисгэхэд загасчид жуумалзаж суув. Гэвч хэдхэн секундын дараа онгоц унтарч, нуурын эргийн төгсгөлд намаг шалбааг бүхий уудам задгай газарт осолджээ.

Нэртэй тохиолдол болох “газрын нөлөө”-нөөс гарах үедээ онгоц нь унтарчээ.

“Газрын нөлөө” нь онгоцны далавч болон газрын гадаргуу хоёр хоорондоо ойрхон байх үед эдгээрийн хооронд агаар шахагдахад нэмэлт хүчийг үүсгэдэг аж. Энэ нөхцөлд онгоц нь “газрын нөлөөнөөс” гарч аажмаар дээш хөөрөн өөрийн хүч, болон өргөлтөөр нисэх ёстой байтал, тэгж чадсангүй.

Азаар хэн ч ноцтой гэмтээгүй бөгөөд ухаан орсныхоо дараа загасчдын нэг нь нөгөөгөөсөө “Юу болсон бэ?” гэж асуужээ. Тэгэхэд нөгөөдөх нь, “Бид газраас хөөрөх үедээ осолдлоо. Өнгөрсөн жил унасан газраас ойролцоогоор 91 метрийн

зайтай” гэж хариулжээ.

Энэ хоёр загасчны адил бид өөрсдийнхөө нөхцөл байдалд тохируулан Их Эзэний зарлигуудыг , товчилсон арай амархан замаар биелүүлж болно гэж заримдаа үздэг.

Иймэрхүү бодол Бурханы хуулиудыг чандлан дагах нь Түүний адислалыг авчирдгийн сацуу Түүний хуулиудыг дагахгүй бол урьдчилан хэлж болшгүй үр дагаварт хүргэх болно гэдгийг хүлээн зөвшөөрүүлдэггүй юм.

Харольд Б. Лий Сүмийн Ерөнхийлөгч байх үедээ, ингэж хэлжээ, “Сүмийн аюулгүй байдал нь зарлигуудыг гишүүд хэр зэрэг сахихаас хамаардаг...Тэд зарлигуудыг сахисан үед адислалууд ирэх болно”¹

Бид аль зарлигийг дагахгүй байхаар сонгох нь ихэвчлэн дараах зүйлсээс болдог:

(1.) Уг зарлиг бидэнд хамаагүй гэж бид өөрсдөдөө итгүүлдэг; (2) энэ нь чухал юм гэдэгт бид итгээгүй байдаг; эсвэл (3) уг зарлигийг дуулгавартай дагах нь дэндүү хэцүү юм шиг санагддаг.

1. Энэ зарлиг надад хамаагүй шүү дээ

Хаан Соломоны хаанчлалын сүүлийн хэдэн жилд Их Эзэн нэг бошиглогчоор дамжуулан түүнд, “Би чамаас хаанчлалыг үнэхээр салган авч, зарцад чинь өгөх болно”² гэж мэдэгджээ.

Түүнээс хойш удалгүй бошиглогч Ахиа Иеробоамыг уг зарц гэдгийг танин хэлсэн юм. Иеробоам нь “хөдөлмөрч”³ нэгэн бөгөөд Соломон түүнийг “Иосефын гэрийн бүх хөлсний ажилчдын дээр”⁴ тавьжээ. Иеробоамын хүлээсэн үүрэг нь түүнийг амьдарч байсан Ефраимын уулархаг нутгаас Иерусалим нийслэл уруу явахыг шаардсан аж. Тэдгээр аялалуудын нэгнийх нь үеэр Ахиа түүнтэй замд уулзсан аж. Их Эзэн Ахиагаар дамжуулан, “Би...арван овгийг нь чамд өгөх болно” гэж түүнд мэдэгджээ. Тэрээр мөн Иеробоамд “хэрэв чи миний замаар явж...миний тушаал,

заавруудыг мөрдвөл...Би чамтай хамт байх болно...мөн Израилыг чамд даатгана”⁵
гэжээ.

Ахиагийн бошиглолыг сонсоод Соломон айж Иеробоамыг Египет уруу явахад хүргэжээ. ⁶ Соломоныг нас барсны дараа Иеробоам Израилын хойд хэсэгт Египетээс буцаж ирэн хойд хэсгийн овгуудыг захирч суусан юм.⁷

Гэвч Иеробоамын хаант улсыг захирах төлөвлөгөөнд сайн, муугийн аль аль нь байсан юм. Тэрээр өөрийнх нь хүмүүст шашны агуу ач холбогдолтой хот Шехемийг нийслэлээ болгожээ. Гэвч харамсалтай нь, тэрээр хүмүүсийн шүтлэг бишрэлийг Сатаны ёстой хольж хутгажээ.⁸

Иеробоам Бурханы зарлигуудын зарим нь өөрт нь хамаагүй гэдэгт итгэсэн байлаа. Түүний энэ уршигт явдлын улмаас үр удам нь хядуулж, тэдний ариун зарчмуудад бий болгосон балмад хэрэг явдлын улмаас Израилын арван овог өв залгамжлалаасаа зайлуулагдсан билээ.⁹

Онгоцны далавч даахаас илүү ачаатайгаар “газрын нөлөө”-нөөс гарч нисэх гэж оролдсон нь гамшигт үр дагаварт хүргэсэн шиг, бид Бурханы хуулиудын зөвхөн заримыг нь эсвэл өөрсдийн сонгосон хэсгийг дагавал дуулгавартай байдлын адислалыг бүрнээр нь авч чадахгүй.

2. Энэ зарлиг чухал биш ээ

Хэдэн арван жилийн дараа Сирийн дайны баатар, “эрэлхэг дайчин эр”¹¹ Нааман унасан, газар угаасан уснаасаа Иудейд ирж, хаан Иерохамд хандан өөрийг нь уяман өвчнөөс эдгээж өгөхийг хүссэн юм.¹¹

Нааманыг бошиглогч Елиша уруу илгээсэн бөгөөд, “...Елиша түүн уруу элч явуулан, Явж Иорданд долоон удаа булх, тэгвэл бие махбод чинь цэвэршинэ гэж хэлүүлжээ.”¹²

Өөрийг нь эдгэнэ гэсэн бошиглолын амлалтыг нь үл тоомсорлон Елишаг өөрийн биеэр ирж мэндлээгүйд нь Нааман гомдож, жижиг бөгөөд шавар намагтай Иордан голд долоон удаа булх гэсэн бошиглогчийн зааварт бүр их гомдон хилэгнэсэн гэдэг. Түүний бардам зан улс орон, нийгэм дэх албан тушаал, нэр хүндэд нь тохирсон илүү том, анхаарал татсан зүйлийг шаарджээ.

Аз болоход Нааманы зарц нар бошиглогчийн хэлснийг дуулгавартай дагавал Их Эзэний адислалууд ирнэ гэдэгт түүнийг итгүүлжээ. Нааман, зааварласны дагуу Иордан голд биеэ угааж, дуулгавартай дагасныхаа ачаар уяман өвчнөөс эдгэрсэн юм.¹³

Чухал эсвэл чухал биш гэж санагдсан ч Их Эзэний зарлигуудад дуулгавартай байх нь Түүний амласан адислалуудыг үнэхээр авчирдаг юм.

3. Энэ зарлиг хэтэрхий хэцүү юм аа.

Их Эзэний зарлигийн дагуу бошиглогч Лихай гэр бүлээ аглаг буйдад авч явжээ.

Аяллынхаа эхний хэдэн хоногт Лихай ууган хүү Лемүелдээ, “Их Эзэний зарлигуудыг дагахдаа чи тууштай бас гуйвшгүй мөн эргэлзээгүй бай”¹⁴ хэмээн захижээ.

Гэвч бошиглосон зарлигийн дагуу “иудейчуудын цэдэг”-ийг¹⁵ агуулдаг гуулин ялтсуудыг буцааж авахаар Иерсалимд буцах болоход том хөвгүүд нь гомдоллож, “хүнд бэрх [зүйл]”¹⁶ гэв.

Нифай ах нарынхаа эсэргүүцэн бувтналдахыг үл тоон Их Эзэний зарлигт дуулгавартай бөгөөд итгэлтэй байсан учир тэдгээр гуулин ялтсуудыг авахад хөтлөгдсөн юм. Улс үндэстэн байгуулагдаж, хэл нь хадгалагдан, Есүс Христийн сайн мэдээг ирээдүйн өч төчнөөн олон үеийнхэнд заасан юм.

Бидний хүн бүрийн өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалан Их Эзэний хуулиудад үнэнч байх нь хэцүү, ичиж зовмоор бас дарамттай зүйл болохоор Тэрээр бидний

дуулгаваргүй байдлыг ойлгох болно гэж бид заримдаа бодож болох юм. Гэвч үүрэг хариуцлагын хэмжээнээс үл шалтгаалан итгэлтэйгээр дагах нь Их Эзэний удирдамж, зөвлөгөө, амар амгаланг авчрах болно.

Нэр нөлөөтэй найз Мартин Харрис нь “Лихайн ном”-ын орчуулагдсан гар бичмэлийн эхний 116 хуудсыг Пеннсилъванийн Хармонигаас Палмира уруу авч явж болох эсэхийг Бошиглогч Иосеф Смит Их Эзэнээс хоёр удаа асуусан ажээ.

Хоёр удаа хоёуланд нь Их Эзэн Харрис ахад гар бичмэлийг итгэл хүлээлгэж өгөхөөс зайлхийхийг Иосефт зөвлөжээ.¹⁷

Мартин өөрийнх нь тухай болон Иосеф Смит тэр хоёрын нөхөрлөлийн талаар найз нарынхаа тарааж байсан цуурхлыг дарахын тулд орчуулагдсан хуудсуудыг баримт болгон үзүүлэхээр төлөвлөж байжээ. Гурав дахь удаагаа гуйхад нь Их Эзэн Иосефын хүсэлтийг зөвшөөрчээ.¹⁷

Мартин гар бичмэлүүдийг алдсан бөгөөд үүнээс болж Бошиглогч Иосеф Смитээс ялтсууд хэсэг хугацаанд буцааж авагдсан юм. Энэхүү сэтгэл эмзэглэм сургамж, бошиглогч Иосеф Смитийг, “Би өөртөө дүрэм гаргалаа, *Их Эзэн зарлиг болгосон л бол, биелүүл*” гэж хэлэхэд хүргэжээ.¹⁸ Энэ нь бас бидний дүрэм байж болно.

Их Эзэний зарлигуудыг дагахад Түүнээс ирэх хариу баттай байдаг. Тэрээр бидэнд “Хэрэв чи миний зарлигуудыг сахиж мөн эцсээ хүртэл тэвчих аваас... мөнх амьдралтай байх болно”¹⁹ гэж амласан юм.

Тэрээр мөн нэмж, “Их Эзэн бибээр, надаас эмээдэг тэдэнд нигүүлсэнгүй хийгээд ач ивээл байх бөлгөө, мөн зөв шударга ёсонд хийгээд үнэнд эцсээ хүртэл надад үйлчилдэг тэднийг хүндэтгэхдээ *баяртай* байдаг” гэж зөвлөжээ.²⁰

Их Эзэний зарлигт дуулгавартай байх нь бидэнд сонгосон зам дээрээ байх итгэлийг болон бидний хичээл зүтгэлд удирдамж, зааврыг өгдөг. Мөн энэ нь бидэнд Аврагч, Есүс Христтэй адилхан болж, Эцэгийнхээ дэргэд эргэж очих боломжийг олгодог.

Есүс Христийн сайн мэдээний зарлигууд, ёслолууд болон хуулиудад илүү дуулгавартай байхыг бид өдөр бүр хичээхийн төлөө, үүний ачаар Их Эзэн бидний амьдралыг илүү бүрэн дүүрэн адислахын төлөө би залбирч байна.

Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь тэнгэрийн адислалыг бидэнд авчирдаг гэдгийг би гэрчилж байна. Мөн Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү, Есүс Христ амьд бөгөөд Мормоны Ном бол Бурханы үг, Ерөнхийлөгч Томас С. Монсон Их Эзэний өнөө үеийн бошиглогч мөн гэдгийг би гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Харольд Б.Лий Stephen W. Gibson, “Presidency Meets the Press,” *Church News*, 1972 оны 7-р сарын 15, 3-т эш татжээ.
2. Хаадын Дээд 11:11
3. Хаадын Дээд 11:28
4. Хаадын Дээд 1:31
5. Хаадын Дээд 11:38
6. Хаадын Дээд 11:40-ийг үз.
7. Хаадын Дээд 12:2-3, 20-ийг үз.
8. Хаадын Дээд 12:25-30-ийг үз.
9. Хаадын Дээд 14:10, 15-16-г үз.
10. Хаадын Дэд 5:1.
11. Хаадын Дэд 5:5-6-г үз.
12. Хаадын Дэд 5:10.
13. Хаадын Дэд 5:11-14-ийг үз.

14. 1Нифай 2:10.

15. 1Нифай 3:3.

16. 1Нифай 3:5.

17. *History of the Church*, 1:20--21; Сургаал ба Гэрээ 3; 10-ыг үз.

18. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 160.

19. Сургаал ба Гэрээ 14:7.

20. Сургаал ба Гэрээ 76:5; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.